

**ШҮҮГЧИЙГ ТУРШИЛТААР АЖИЛЛУУЛЖ БУЙ ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА¹
ЛАВЛАГАА**

Оршил

Тус лавлагаагаар гадаадын зарим орнуудад шүүгчийг туршилтаар ажиллуулж буй байдал, ямар шат дамжлагыг дамжиж, үндсэн шүүгчээр томилогддог болохыг Япон, Эстони, Швед, Англи улсын хууль зүйн зохицуулалт, туршлагаас судлахыг зорив. Учир нь эдгээр орнуудад байнгын орон тооны буюу үндсэн шүүгчээр томилогдохын өмнөх бэлтгэл болгож туслах шүүгчийн /assistant judge/ орон тоог бий болгожээ.

Мөн дадлага, туршлагатай өмгөөлөгч нараас шүүгчдийг шилж сонгох явдлыг хөхүүлэн дэмжих үүднээс тухайлбал Япон улсын хувьд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд өмгөөлөгч нарыг хагас цагийн шүүгчээр /part-time judge/ ажиллуулах, Англи улсын хувьд хөнгөвтөр эрүү, иргэний хэргийг шүүн таслах ажлыг хагас цагийн шүүгч явуулах байдлаар уг тогтолцоог нэвтрүүлсэн байна.

Харин Швед, Эстони зэрэг улсуудад эхлээд шүүгчийн туслах, туслах шүүгчээр тодорхой хугацаанд ажиллаж, шүүгчээр ажиллах дадлага туршлагыг хуримтлуулсны дараа байнгын орон тооны буюу үндсэн шүүгчээр томилогддог тогтолцоотой байна. Ингээд эдгээр орны зохицуулалтыг дор дэлгэрүүлэн авч үзье.

1. Япон улс

1.1. Туслах шүүгч

Туслах шүүгч гэдэг нь шүүгчээр томилогдоод 10 жил болоогүй байгаа шүүгчийг хэлдэг (гэхдээ өмгөөлөгч, прокуророор ажилласан жил тоологдоно). Туслах шүүгчийг шүүгч бэлтгэх сургалтыг дүүргэсэн хүмүүсээс сонгон томилдог (Шүүхийн тухай хуулийн 43-р зүйл). Туслах шүүгчээр 3 жил ажиллаад Хөнгөн хэргийн шүүхийн шүүгчээр, 10 жил ажиллаад үндсэн шүүгчээр томилогдох боловч Дээд шүүхийн дэргэдэх доод шатны шүүхийн шүүгчийг томилох зөвлөлөөс “шүүгчээр томилоход тохиромжгүй” гэсэн шийдвэр гарвал шүүгч болохгүйгээр ажлаасаа чөлөөлөгддөг байна. Энэ тохиолдолд өмгөөлөгч болох эрхтэй боловч Хөнгөн хэргийн шүүхийн шүүгч болох боломжгүй болдог.

Туслах шүүгч нь дангаараа хэрэг хянан шийдвэрлэх эрхгүй (Шүүхийн тухай хуулийн 27.1) бөгөөд зөвхөн бүрэлдэхүүнээр шийдвэрлэх хэрэгт шүүгчээр оролцоно. Мөн бүрэлдэхүүнд багтсан тохиолдолд даргалагч шүүгч болохгүй (мөн зүйлийн 27.2). Гэвч туслах шүүгчээр томилогдоод 5 жил болсон шүүгчдээс Дээд шүүхийн нэрлэсэн шүүгчийг тусгай туслах шүүгчээр томилон, онцгой тохиолдолд дангаар хэрэг хянан шийдвэрлэхийг нь зөвшөөрөх тохиолдол бий. Мөн туслах шүүгч нь шүүхийн шийдвэр гаргахаас бусад иргэний болон эрүүгийн шүүхийн шүүн таслах ажиллагааг дангаар явуулах эрхтэй. Тухайлбал шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах ажиллагаа, эд хөрөнгө битүүмжлэх, нэгжлэг явуулах, үзлэг хийх зэрэг албадлагын арга хэмжээ авах захирамж гаргах, өсвөр насны хүний хэргийг дангаар хянан шийдвэрлэх эрхтэй байна.

1.2. Орон тооны бус шүүгч

Орон тооны бус шүүгч гэдэг нь өмгөөлөгч хийнгээ долоо хоногт нэг удаа шүүх дээр ирж, иргэний болон гэр бүлийн хэргийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд шүүгчээр

¹ Лавлагааг ШСМСХ-ийн судлаач Б.Хонгорзул боловсруулав.

ажилладаг тогтолцоо юм.² Япон улс нь манайхаас ялгаатай нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын хувьд хэрэг бүр дээр 2 эвлэрүүлэн зуучлагч, 1 шүүгчийн бүрэлдэхүүнтэй эвлэрүүлэн зуучлалын зөвлөл байгуулагдаж, хэргийг шийдвэрлэдэг. Бүрэлдэхүүнд багтсан шүүгч нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хяналт тавьж ажилладаг.

Өмгөөлөгч хүн ийнхүү эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд шүүгчийн нэгэн адил эрх хэмжээтэй оролцож, ажилладаг энэхүү орон тооны бус шүүгчийн тогтолцоо нь 2002 онд нэвтэрсэн юм. Тус тогтолцоо нь нэгдүгээрт өмгөөлөгчөөс шүүгч болохыг дэмжих эрх зүйн орчныг бий болгох, хоёрдугаарт эвлэрүүлэн зуучлах ажиллагааг амжилттай сайн явуулах зорилготойгоор бий болсон байна.³

Орон тооны бус шүүгч нь өөрийн хариуцсан хэргийн эвлэрүүлэн зуучлах ажиллагааны тэмдэглэлтэй танилцах, эвлэрүүлэн зуучлагч нартай хэргийн талаар зөвлөлдөх, эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцох зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг. Төрөл бүрийн хэргийг хариуцах боловч өмгөөлөгчийн мэдлэг, туршлагаа гаргах бололцоотой хэрэг буюу ээдрээ төвөгтэй, эрх зүйн маргаантай асуудал ихтэй хэргийг голлон хариуцдаг.⁴

Орон тооны бус шүүгч нь тухайн шүүхтэйгээ ярилцаад долоо хоногийн тогтсон нэг өдөр өглөө 9 цагаас орой 17 цаг хүртэл ажилладаг байна. Нэг өдрийн ажлын хөлс нь 30,700 иен (2017.04.01 байдлаар) бөгөөд илүү цагийн ажлын хөлс бодогдохгүй боловч унаа болон байрны хөлс олгогддог байна.⁵

2 жилийн хугацаатай томилогдох боловч 1 удаа дахин сонгогдох эрхтэй бөгөөд нийт 4 жил ажиллах боломжтой байна.⁶

Тавигдах шаардлагын хувьд:

1. Долоо хоногт 1 удаа 1 бүтэн ажлын өдөр ажиллах боломжтой байх
2. 5 жилээс дээш өмгөөлөгчийн ажлын туршлагатай байх
3. 55 хүртэлх насны иргэн байх (орон тооны бус шүүгчээс орон тооны буюу үндсэн шүүгчээр томилогдох тохиолдолд тодорхой хугацаанд ажиллах насыг харгалзан ийнхүү насны хязгаарлалт тогтоожээ)
4. Ял шийтгэлгүй байх

Тогтолцоо хэрэгжиж эхэлсэн 2004 оноос 2016 он хүртэлх хугацаанд нийт 16 хүн орон тооны буюу үндсэн шүүгчээр томилогдсон байна.⁷

2. Эстони улс

Тус улсад туслах шүүгч /assistant judge/ гэсэн ойлголт байдаг.⁸ Туслах шүүгч нь хуульд зааснаар үндсэн шүүгчийн зааврын дагуу ажиллана. Туслах шүүгч нь магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуулийн хууль зүйн магистрын зэрэгтэй байх эсхүл Эстони улсын боловсролын тухай хуулийн 28.2-т зааснаар үүнтэй тэнцэхүйц боловсрол эзэмшсэн байх, эсхүл үүнтэй тэнцэхүйц боловсролыг гадаадад эзэмшсэн байх, өндөр түвшний Эстони хэлтэй байх, өндөр ёс зүйтэй байх, туслах шүүгч бэлтгэх сургалтад хамрагдсан байх шаардлага тавигддаг. Туслах шүүгч бэлтгэх сургалтад хамрагдаагүй

² Япон Улсын Өмгөөлөгчдийн холбоо “Орон тооны бус шүүгчийн тогтолцооны талаарх асуулт, хариулт” гарын авлага, 1 дэх тал.

³ Мөн тэнд.

⁴ Мөн тэнд.

⁵ Мөн тэнд, 2 дахь тал.

⁶ Мөн тэнд, 3 дахь тал.

⁷ Мөн тэнд, 5 дахь тал.

⁸ https://e-justice.europa.eu/content_legal_professions-29-ee-en.do?member=1 уг сайтаас дэлгэрүүлэн үзнэ үү.

хэдий ч шүүгч бэлтгэх сургалтад хамрагдсан бол бэлтгэх сургалтаас чөлөөлөгдөх бөгөөд шүүгчийн шалгалтад тэнцсэн бол туслах шүүгчээр мөн томилогддог байна.

Эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн, ажлаасаа огцорсон шүүгч, нотариат, орчуулагч, хэлмэрч, шийдвэр гүйцэтгэгч, Эстонийн барын холбооноос хөөгдсөн этгээд, сахилгын зөрчил гаргаж, төрийн албан тушаалаас чөлөөлөгдсөн этгээд, дампуурсан этгээд, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх нь дуусгавар болсон этгээд (хуулийн дагуу дуусгавар болсон бол хамаарахгүй), патентын олгох эрх бүхий байгууллагад ажиллах эрх нь түдгэлзсэн этгээд (хуулийн дагуу бол хамаарахгүй), шүүгчээр ажиллахад тохиромжгүй хэмээн үүрэгт ажлаасаа огцорсон шүүгч нь туслах шүүгчээр томилогдох боломжгүй байна.

Туслах шүүгч нь шүүхийн шийдвэр гаргахтай холбоотой тусгай эрх хэмжээтэй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдсон талуудын хүсэлтийг шийдвэрлэх, бүртгэл хийх, төлбөр гаргуулах захирамжийг биелүүлэхтэй холбоотой өргөдөл, хүсэлтийг хянах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

3. Швед улс

Шүүгч болоход Швед улсын иргэншилтэй байх ёстой.⁹ Мөн шүүгч болоход Шведийн их дээд сургуульд эрх зүйн боловсрол эзэмшсэн байх шаардлагатай. Зарим тохиолдолд Скандинавийн орнуудад хууль зүйн сургалтад хамрагдсан бол эрх зүйн зэрэгтэй тооцогддог байна. Орон тооны буюу үндсэн шүүгчдийн ихэнх нь дүүргийн шүүх болон захиргааны хэргийн шүүхэд мөн давж заалдах шатны шүүх болон захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд ажилладаг. Орон тооны буюу үндсэн шүүгчээр томилогдохын тулд эхлээд 2 жил дүүргийн шүүхэд туслахаар ажиллаж, үүний дараа давж заалдах шатны шүүх болон захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд туслахаар ажиллана. Эдгээр шүүхүүдэд дор хаяж 1 жил ажилласны дараа дадлагажигч шүүгч нь дүүргийн шүүх болон захиргааны шүүхэд доод тал нь 2 жил туслахаар ажиллах ёстой байна. Үүний дараа давж заалдах шатны шүүх эсхүл захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд туслах шүүгчээр дор хаяж 1 жил ажиллана. Шүүгч бэлтгэх сургалтыг амжилттай дүүргэсний дараа дадлагажигч шүүгч нь давж заалдах шатны шүүх болон захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд туслах шүүгчээр томилогдоно. Шүүгчийн туслах болон туслах шүүгч нь орон тооны буюу байнгын шүүгчийн статусгүй шүүгч нар юм.

4. Англи улс

Англи улсад бүтэн цагийн болон хагас цагийн гэсэн 2 төрлийн шүүгч байдаг.¹⁰

Бүтэн цагийн шүүгч /Full-time judge/

Английн дээд шүүх, түүний 4 том хэлтэс болох иргэний хэргийн хэлтэс, хатан хааны хэлтэс, гэр бүлийн хэргийн хэлтэс, канцлерын хэлтсийн тэргүүн, давж заалдах шатны шүүхүүд, ээдрээ төвөгтэй иргэний хэрэг, хүнд, ноцтой эрүүгийн хэргийг харьяалан шийдвэрлэдэг дээд шатны шүүхийн шүүгч нар, эрүү, иргэн, гэр бүлийн хэргийг харьяалан шийдвэрлэдэг тойргийн шүүгч нар, иргэний хэргийг голлон шийдвэрлэдэг дүүргийн шүүгч нар, эрүүгийн хэргийг голлон шийдвэрлэдэг дүүргийн шүүгч нар, мөн

⁹ https://e-justice.europa.eu/content_legal_professions-29-se-en.do?member=1 уг сайтаас дэлгэрүүлэн үзнэ үү.

¹⁰ https://e-justice.europa.eu/content_legal_professions-29-ew-en.do?member=1 уг сайтаас дэлгэрүүлэн үзнэ үү.

дээд шатны шүүхийн канцлер болон хатан хааны хэлтсийн харьяаллын бизнесийн маргааны дийлэнхийг шийдвэрлэдэг шүүгч нар нь бүтэн цагийн шүүгч нар байдаг байна.

Хагас цагийн шүүгч /Part-time judge/

Харин хагас цагийн шүүгч нар нь 5 хүртэлх жилээр томилогддог. Хагас цагийн шүүгчид доорх төрлийн шүүгч нар хамаарна. Үүнд:

- Дээд шатны шүүхийн туслах
- Тойргийн шүүгчтэй адил төрлийн хэргийг харьяалан шийдвэрлэх боловч ерөнхийдөө хөнгөн төрлийн хэргийг шийдвэрлэдэг туслах шүүгч
- Дүүргийн шүүгчийн харьяаллын хөнгөвтөр хэргийг шийддэг дүүргийн шүүгчийн туслах
- Дүүргийн эрүүгийн хэргийн шүүгчийн туслах
- Дээд шатны шүүхийн шүүгчийн туслах зэрэг шүүгч нар багтдаг байна.

Дүгнэлт

Дээрхээс дүгнэхэд эдгээр орнуудад шүүгчийг нарийн сонгон шалгаруулалтаар сонгон авсны дараа шатны шатны шүүхэд хөнгөвтөр төрлийн хэргийн шүүн таслах ажиллагаанд туслуулах замаар тодорхой хугацаанд дадлагажуулсны дараа байнгын орон тооны буюу үндсэн шүүгчээр томилдог сайн туршлага байгаа нь ажиглагдаж байна. Ялангуяа Япон улсын хувьд туслах шүүгчээр 3 жил ажиллаж байж Хөнгөн хэргийн шүүхийн шүүгч, 10 жил ажиллаж, дахин шалгалт өгч үндсэн шүүгч болдог нь харахад шүүгчид ямар өндөр шалгуур тавигддаг нь харагдаж байна. Мөн тус улсад туслах шүүгч нь шүүхийн шийдвэр гаргадаггүй, зөвхөн бүрэлдэхүүнтэй шүүх хуралдаанд оролцож, даргалагч шүүгчээр ажилладаггүй байна. Харин шүүхийн шийдвэр гаргахад бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой шүүгчийн захирамж гаргах, мөн өсвөр насны хүний хэргийг хянан шийдвэрлэж, шүүн таслах ажиллагааны дадлага туршлагыг хуримтлуулдаг байна.

Харин манай улсын хувьд шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн хүн шүүгч бэлтгэх богино хугацааны сургалтад хамрагдаж, шууд шүүгч болж байгаа нь эдгээр орнуудтай харьцуулахад шүүгч гэдэг өндөр хариуцлагатай албан тушаалыг хашихад шаардлагатай шүүн таслах ажиллагааны дадлага туршлага хангалтгүй байдаг болов уу гэсэн эргэлзээг төрүүлдэг. Иймд дээрх орнуудын адилаар шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцэж, шүүгч болсны дараа тодорхой хугацаанд туслах шүүгчээр ажиллаж, шүүн таслах ажиллагааны дадлага туршлагыг хуримтлуулсны дараа үндсэн шүүгч болдог тогтолцоог манай улс ч мөн адил харгалзан үзэх нь зүйтэй санагдаж байна.